



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/111

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх, даацыг тодорхойлох хээрийн судалгааны ажлыг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мөнхзаяа

(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Т.Өлзийбуд

(Байгаль орчны асуудал харицсан мэргэжилтэн)


2.Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх, хээрийн судалгаа хийх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Бэлчээрийн даац тодорхойлох ажлыг удирдамжийн дагуу чанартай, хугацаанд нь зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Мөнхзаяа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Н.СУГАРМАА



Сумын Засаг даргын 2023 оны
08 сарын 07 өдрийн 111 тоот
захирамжийн хавсралт

**БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ФОТОМОНИТОРИНГИЙН
АРГААР ҮНЭЛЭХ ХЭЭРИЙН СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

НЭГ. Зорилго

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх хээрийн судалгааг хийх тухайн бүс нутагт жил бүр давтамжтайгаар бэлчээрийн өөрчлөлтийг тодорхойлох фотомониторингийн цэг байгуулах, цэгийн мэдээллийн санг үүсгэх, бэлчээр ашиглалтын хэсэгт үнэлгээ өгч, зохих арга хэмжээг авч багийн иргэдийн нийтийн хурал болон сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлан мэдээг танилцуулж үнэлгээ дүгнэлт өгөхөд энэхүү ажлын гол зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Сумын 2 дугаар багийн бэлчээр ашиглалтын 3 хэсгийн 9 цэг

Гурав. Хугацаа

2023 оны 08 дугаар сарын 7-ноос 08 сарын 10-ний өдрийн дотор

Дөрөв. Явах чиглэл

Сумын төв-Эрдэнэ толгой- Гозгор толгой- Сэвхүүлийн говь- Зүйтийн тал- Дэвсэг толгой- Бэхтийн ухаа- Хүрэн дух- Найман шороо-Хавхагт- сумын төв нийт 250км.

Хүрэх үр дүн:

- Бэлчээрийг зохистой ашиглах, бэлчээрийн нөөц, бэлчээрийг нөхөн сэргээх, бэлчээр зохион байгуулалтыг төлөвлөх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болно.
- Бэлчээрийн даацыг тогтоож үнэлгээ хийснээр хонин толгойгоор илэрхийлсэн бэлчээрийн чадавхийг бэлэн байгаа малын тоотой харьцуулан бэлчээрийн даац хэтэрсэн эсвэл дутуу ашиглаж байгаа болон нөхөн сэргээх шаардлагатай эсэхийг тодорхойлно.

➤ Бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох ургацын дээж авах цэгийн тоог сумынхаа нутаг дэвсгэрт байгаа бэлчээрийн үндсэн төрөл, хэв шинжийг төлөөлж чадахүйц хэмжээнд нэмэгдүүлэх, бэлчээрийн ургацын мэдээллийг сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловруулахад ашиглах

Хавсаргах баримт, бүрдүүлэх багаж, унаа машин:

- Ажил гүйцэтгэхэд шаардагдах шатахууны зардлын тооцоо /хүснэгт №1/
- Багаж авч явах /хайя 2 ш, гялгар уут, 50 метрийн урттай метр, 1м2-ийн тор,
- Унаа машин олох
- GPS багаж
- Зургийн аппарат

Удирдамж боловсруулсан:

Газрын даамал:  Т.Өлзийбуд